


135
Захирлын 2021 оны 04 дүгээр
сарын 26-ны өдрийн А/28 дугаар
тушаалын 6 дугаар хавсралт



БАГШ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Үндэслэл

Монгол улсын Үндсэн хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль, Боловсролын тухай хууль, Бага дунд боловсролын тухай хууль, Авлигын эсрэг хууль, төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн энэхүү журмыг боловсруулав.

Сургуулийн сул ажлын байрны сонгон шалгаруулалтыг ажлын байранд тавигдах шаардлагад нийцсэн, чанартай боловсон хүчнээр хангах, сонгон шалгаруулалтыг ашиг сонирхлын зөрчилгүй, авлигаас ангид байлгах, шударга, нээлттэй ил тод зохион байгуулахад энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Тус сургууль нь нь иргэдийг ажилд авах шийдвэр гаргахдаа арьс өнгө, нас, хөгжлийн бэрхшээлтэй байдал, шашны итгэл үнэмшил, намын харъяалалаар ялгаварлан гадуурхахгүй.

Хоёр. Зорилго

Сургуулийн хүний нөөцийн төлөвлөлтөд судалгаатай хандан, сул ажлын байрыг нийтэд зарлаж, багш сонгон шалгаруулах ажлыг шударга зохион байгуулж, нээлттэй мэдээллэн, мэргэжлийн дэмжлэг үзүүлэн ажиллаж, хүний нөөцийг чадавхижуулахад чиглэнэ.

Гурав. Сонгон шалгаруулалтын бэлтгэл ажил

3.1. Хүний нөөцийг бүрдүүлэх сонгон шалгаруулалтыг сургуулийн захирлын тушаалаар томилогдсон ажлын хэсэг зохион байгуулна. Бүрэлдэхүүнд хариуцсан сургалтын менежер, ЗАНэгдлийн ахлагч, мэргэжлийн багш, эцэг, эх, иргэний нийгмийн төлөөлөл оролцож болно.

3.2. Сул ажлын байрыг зарлах:

3.2.1. Багш жирэмсний амралт авах, урт хугацааны чөлөө авах, ажлаас чөлөөлөгдөх мэдээллийг нэг сарын өмнө авч сул ажлын байрны нэгдсэн судалгааг гаргах

3.2.2. Ажлын байрны захиалга мэдээллийг ажил хайгчдад хүргэх, нийтэд цахим болон бусад хэлбэрээр мэдээлэх.

3.2.3. Ажлын байрны зар нь тодорхой ур чадвар, хандлагыг нээж илрүүлэхэд чиглэгдсэн байх ба дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

- а. Албан тушаалын нэр
- б. Ажлын байрны байршил
- в. Албан тушаалын зорилго, гүйцэтгэх үндсэн үүрэг
- г. Шаардаж буй эсвэл давуу тал болох туршлага, боловсрол мэргэшил
- д. Өргөдлөө хэрхэн гаргах тухай
- е. Өргөдөл хүлээн авах эцсийн хугацаа

ё. Холбоо барих мэдээлэл зэрэг орно.

3.3. Ажлын байрны зарыг ажлын 3-5 хоног байршуулан, сонгон шалгаруулалтыг товлосон хугацаанд явуулна.

3.4. Сонгон шалгаруулалтад шаардлагатай даалгаврын сан бүрдүүлж, үнэлгээг хийх ажлыг ажлын хэсэг зохион байгуулна.

3.5. Бүртгэх

3.5.1. Боловсролын салбарт ажиллах хүсэлтэй, багш бэлтгэдэг их, дээд сургууль төгссөн ажил идэвхтэй хайж байгаа иргэдийг бүртгэж, мэргэжлийн түвшинд үнэлгээ хийн бүртгэнэ.

3.5.2. Ажлын байрны тодорхойлолтыг үндэслэсэн хийгдсэн шалгуур шаардлагыг чиглэл болгон бүртгэнэ.

3.5.3. Оролцогч нь бүртгүүлэхдээ дараах бичиг баримтыг бүрдүүлж ирнэ. Баримт дутуу бол мэргэжлийн түвшин тогтоох үнэлгээнд орохгүй.

- Багш мэргэжлийн диплом, бусад диплом
- Иргэний үнэмлэх
- Багшлах эрхийн үнэмлэх, мэргэжлийн зэргийн үнэмлэх
- Шаардлагатай тохиолдолд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт, амжилт бататгах бусад баримт бичиг
- Мэргэжил дээшлүүлсэн сургалтад хамрагдсан сертификат болон дүйцүүлэх бусад бичиг баримт
- Иргэний хувийн өргөдөл

3.5.4. Мэргэжлийн шаардлага хангасан байдлыг 5 оноогоор үнэлнэ.

- Бакалаврын зэрэгтэй бол 2, магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй бол 3 оноо. (зайлшгүй тохиолдолд дипломын зэрэгтэй бол-1 оноо)
- Багшлах эрх, мэргэжлийн зэрэгт 2 оноо. Багшлах эрхтэй бол 1 оноо, заах аргач мэргэжлийн зэрэгтэй бол 0,5 оноо, тэргүүлэх болон түүнээс дээш мэргэжлийн зэрэгтэй бол 1 оноо.

3.5.5. Албан тушаалын шаардлага хангасан тохиолдолд мэргэжлийн боловсон хүчин байхгүй бол ажлын хэсэг үнэлгээжүүлэн сул ажлын байранд бүртгэж болно.

Дөрөв. Сонгон шалгаруулалт явуулах аргачлал

4.1 Сонгон шалгаруулалт нь 5 хэсгээс бүрдэнэ.

4.1.1. **Багшийн бэлтгэгдсэн байдал**-15 оноо

Монгол хэлний хэрэглээний түвшин, компьютерийн хэрэглээний түвшинг тогтоох сорил болон Монгол бичгийн анхан шатны мэдэгдэхүүнийг сорих даалгавар байна. Сорил нь нийт 15 оноотой бөгөөд тус бүр 5 оноотой байна.

4.1.2. **Багшийн дидактик, арга зүй** -15 оноо

Сэтгэл судлал, боловсрол судлалын ерөнхий мэдлэг сорих 6 онооны тус бүр 3 сорил даалгавар болон сургалтын хөтөлбөрийг судалсан байдал, хичээлийн хөтөлбөр боловсруулах, даалгавар боловсруулах дүн шинжилгээ хийх аргачлалыг илрүүлэх 9 онооны даалгавар байна.

4.1.3. Багшийн мэргэжлийн онол-40 оноо

Тухайн мэргэжлийн онолын мэдлэгийг сорих даалгавар байна.

4.1.4. Багшийн хууль, эрх зүйн мэдлэг-10 оноо

Багшийн зайлшгүй мэдвэл зохих хууль эрхзүйн ойлголтуудыг үнэлэх сорил даалгавар байна.

4.1.5. Багшийн хандлага, төлөвшил, ажиллах хүсэл тэмүүлэл-15 оноо

Багшийн хандлага, төлөвшил, ур чадвар, ажиллах чин сэтгэл, хүсэл эрмэлзэлийг ирүүлэх 3 асуулт байх бөгөөд тус бүр 5 оноо өгнө.

4.2 Сонгон шалгаруулалтын 4.1.1-4.1.4-ийг ажлын хэсгийн боловсруулсан сорил даалгавраар, 4.1.5-г сургуулийн захирал, сургалтын менежерийн хамтарсан багийн ярилцлагаар үнэлгээжүүлнэ.

Тав. Сонгон шалгаруулалтын үнэлгээг танилцуулах

5.1. Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтыг үнэлгээг нэгтгэнэ.

5.2. Нэгдсэн үнэлгээг ярилцлагад оролцохоос өмнө сургуулийн захиралд өгөх бөгөөд сургуулийн захирал оролцогчид нэгдсэн үнэлгээг танилцуулж, өөрийн ярилцлагын үнэлгээг мөн танилцуулна.

5.3. Шаардлагатай тохиолдолд оролцогчдод утсаар үнэлгээг мэдэгдэж болно.

Зургаа. Хүлээх хариуцлага

6.1 Ажлын хэсэг энэхүү журмыг зөрчсөн, авилга ашиг сонирхлын зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд ажлаас чөлөөлөгдөх хүртэлх хариуцлага хүлээлгэх ба Авилгын эсрэг хуулийн дагуу Авилгатай тэмцэх газарт мэдээлэх.

6.2 Энэ журмын хэрэгжилтийн тайланг хагас, бүтэн жилээр сургалтын менежер гаргана. Жил бүрийн 5 дугаар сарын 15 болон 12 дугаар сарын 10-ны өдөр тайланг сургуулийн захиралд өгнө.

6.3 Журмын заалтыг мөрдөөгүйгээс үүсэх хариуцлагын буруутай этгээд шууд хүлээх бөгөөд энэ тухай асуудлыг хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд тусгаж зохицуулна.